



САЛБАРЫН МЭРГЭЖЛИЙН
ХОЛБОО

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2018 оны 3 дугаар улирал

Мэргэжлийн **МАНЛАЙЛАЛ**, Салбарын **ДУУ ХООЛОЙ**

 www.mba.mn

 facebook.com/MongolianBankersAssociation

 twitter.com/Mongolianbanker

 +976 11 323581

БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2018 оны 3 дугаар улиралд банкны салбарын нийт хөрөнгө 31 их наяд төгрөгт хүрч, өмнөх улирлаас 774 тэрбум төгрөгөөр өссөн нь ханшийн тэгшитгэлийн нөлөөгөөр бий болсон өөрчлөлт байна. Харин төгрөгөөр байршиж буй актив 20.4 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 363 тэрбум төгрөгөөр буурчээ.



2018 оны эхний улиралд бодлогын хүү болон зайлшгүй байх нөөцийн хувийг зэрэг бууруулсны нөлөө 2 дугаар улиралд гарч, нэг улирлын дотор зээлийн багц 13 хувиар өссөн бол 3 дугаар улиралд зээлийн багцын өсөлт саарсан үзүүлэлттэй буюу 1.9 хувиар өсч, багцын үлдэгдэл 16.1 их наяд төгрөгт хүрсэн. Зээл активийн харьцаа болон зээл хадгаламжийн харьцаа харгалзан 52 хувь болон 101 хувьтай байгаа нь өмнөх улирлын үзүүлэлтээс ялимгүй бага өөрчлөгдсөн бөгөөд харин оны эхнээс 5 болон 11 пунктээр тус тус өссөн үзүүлэлт бөгөөд хөрөнгийн ашиглалт сайжирсныг илтгэж буй үзүүлэлт юм.

Банкуудын зээлийн эрсдэлийн сан сүүлийн 2 улиралд огцом нэмэгдэж байгаатай холбоотой ашигт ажиллагааны хэлбэлзэл өндөртэй байна. Тухайлбал 2018 оны 1 дүгээр улиралд 58.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол 2 дугаар улиралд 26.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, 3 дугаар улиралд 9.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, 2018 оны 10 дугаар сарын мэдээнээс үзэхэд зөвхөн нэг сарын дотор 243 тэрбум төгрөгийн алдагдал бүртгэсэн байдалтай байна. 2018 оны 1-10 сарын хугацаанд банкууд эрсдэлийн сангаа 650 тэрбум төгрөгөөр нэмж байгуулсан бөгөөд энэ хугацаанд өссөн дүнгээр 201 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Харин эрсдэлийн сангийн өмнөх байдлаар 450 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байхаар харагдаж байгаа ба 2017 оны мөн үед банкуудын эрсдэлийн сангийн өмнөх ашиг 310 тэрбум төгрөг байсантай харьцуулахад банкуудын эрсдэлийн сангийн өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг 40 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа. Харин сан байгуулсан зээлүүд эргэн төлөгдөхгүй байх нөхцөл бодитоор үүсвэл банкны системийн 200 тэрбумын алдагдал бодитой болох нөхцөл үүсэх юм.



2018 оны 3-р улиралд чанаргүй зээлийн багц өмнөх улирлаас ялимгүй өсч 1,348 тэрбум төгрөгт хүрч өссөн бол ердөө нэг сарын дараа буюу 2018 оны 10 дугаар сарын эцсээр чанаргүй зээлийн багц 600 тэрбум төгрөгөөр өсч, 1,950 тэрбум төгрөгт хүрснээр нийт зээлд эзлэх хувь 12 болж нэмэгдээд байна. Зээлийн чанар нэг улирлын дотор огцом мүүдсанаас банкны системийн зээлийн чанар нийтээрээ мүүдаж байгаа гэж дүгнэхээс илүү хэдэн банкинд хэдэн харилцагчийн зээлийн ангилалд өөрчлөлт орсныг

тодруулсны дараа дүгнэлт хийх боломжтой болно. Тухайлбал чанаргүй зээлийн өсөлтийн бүтцээс харахад 600 тэрбум төгрөгийн чанаргүй зээлийн өсөлтийн 580 тэрбумыг аж ахуйн нэгжийн зээлийн өсөлт бүрдүүлсэн байгаа бөгөөд иргэдийн зээлийн чанар огцом муудсан үзүүлэлт ажиглагдахгүй байна.

Харин зээлийн чанарын үзүүлэлтийн өөрчлөлт (2018 оны 10 дугаар сар)-ийг салбараар ангилж үзвэл:

- Уул уурхайн салбарын чанаргүй зээлийн багц **204 тэрбум** төгрөгөөр;
- Боловсруулах үйлдвэрийн салбарын чанаргүй зээлийн багц **80.2 тэрбум** төгрөгөөр;
- Барилгын салбарын чанаргүй зээлийн багц **96.3 тэрбум** төгрөгөөр;
- Худалдаа үйлчилгээний салбарт олгосон зээлийн чанар **71.5 тэрбум** төгрөгөөр;
- Үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн чанар **48.2 тэрбум** төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2018 онд зээлийн чанарын үзүүлэлттэй холбоотой системийн ашигт ажиллагаа буурч байгаа нь өөрийн хөрөнгийн хэмжээг буурахад нөлөөлөв. Тухайлбал 2018 оны 10 дугаар сарын байдлаар системийн өөрийн хөрөнгийн хэмжээ 340 тэрбум төгрөгөөр буурч, 2.8 их наяд төгрөгт хүрснээр өөрийн хөрөнгийн хүрэлцээ мөн 16 хувьд хүрч буурлаа. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар зээлийн эрсдэлийн сан болон чанаргүй зээлийн багцын харьцаа буюу эрсдэл даах чадвар 110.7 хувь байсан бол 2018 оны 10 дугаар сарын байдлаар чанаргүй зээлийн багц өссөнтэй холбоотой 85.6 хувь болж буурсан байна.

АРИЛЖААНЫ БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ТОЙМ


Нийт актив. 2018 оны 3 дугаар улиралд системийн нөлөө бүхий банк (СНББ)-уудын нийт хөрөнгө 706 тэрбум төгрөг буюу 2.6 хувиар өссөн байна. Голомт болон Хас банкнаас бусад СНББ-уудын актив өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд Хаан, Төрийн банк, УБХБ активаа тус бүр 5-с дээш хувиар өсгөж чадсан байна.




Бусад банкуудын нийт хөрөнгө 2.1 их наяд төгрөгт хүрч 9.7 хувиар өссөн байна. ҮХОБ болон Кредит банкнаас бусад банкууд активаа өсгөсөн үзүүлэлттэй байгаагийн дотор Богд банкны нийт хөрөнгө 60 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлт байна.

Богд банкны хувьд нэг улирлын дотор банк санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн хэмжээгээ 60 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

СНББ-уудаас бусад банкуудын секторт эзлэх хувь 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 6.9 хувь байгаа нь оны эхнээс 0.5 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.




Цэвэр зээл. Тайлант улиралд СНББ-уудын цэвэр зээл дунджаар 5.6 хувиар өссөний дотор ХХБ, Хаанбанк, Төрийн банк зээлээ 200 орчим тэрбум төгрөгөөр өсгөлөө. Ингэснээр арилжааны банкууд дотроос Хаанбанкны цэвэр зээл анх удаа 4.0 их наяд төгрөгт хүрч байна. Тусбанкны хувьд системийн нийт зээлийн багцын ¼-г дангаараа бүрдүүлж байгаагийн зэрэгцээ зээлийн чанарын үзүүлэлтээр банкны системд хамгийн сайнд тооцогдохоор үзүүлэлттэй байгаа.



Кредит болон ҮХОБ-г эс тооцвол бусад банкуудын цэвэр зээл өссөн үзүүлэлттэй байлаа. Тэр дундаа ТХБ, Аригбанк болон Богд банкны зээлийн багцын өсөлт 20-с дээш хувьтай байна.

Бусад банкууд дотроос 2 банкны чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2 оронтой тоонд хүрсэн байгаа нь анхаарал татаж байна.




Тайлант улиралд СНББ-уудын зээлийн өсөлт 5.6 хувь байгаа бол бусад банкуудын зээлийн өсөлт 8.9 хувь байгаа нь зээлийн зах зээлд өрсөлдөөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Харилцах хадгаламж. 2018 оны 2 дугаар улиралд бүх СНББ-уудын харилцах хадгаламж өссөн үзүүлэлттэй байсан бол 3 дугаар улиралд мөн л ихэнх банкууд дотоодын эх үүсвэрээ өсгөж ажиллалаа. ХХБ болон Хаанбанк, УБХБ-ны харилцах хадгаламж 5-с дээш хувиар өсч, өсөлтийн хурдаар тэргүүлээ.




Бусад банкуудын хувьд ТХБ-ны харилцах хадгаламжийн үлдэгдэл буурсныг эс тооцвол бүгд тодорхой хэмжээгээр өссөн үзүүлэлттэй байлаа. Капитрон банк болон Ариг банк харилцах хадгаламжийн өсөлтөөрөө бусад банкуудыг тэргүүлсэн байна.


Тайлант улиралд СНББ-уудаас бусад банкуудын харилцах хадгаламж 6.3 хувиар өссөн нь мөн л системийн банкуудын өсөлт (3.5%)-өөс өндөр байна.



Цэвэр ашиг. 2018 оны эхний 3 улирлын дараах байдлаар СНББ-ууд бүгд ашигтай ажилласан харагдаж байгаа боловч ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс буурсан дүр зураг ажиглагдаж байна. 2 банкны хувьд ашгийн хэмжээ нэмэгдсэн бол бусад 4 банкны ашигт ажиллагаа буурсан үзүүлэлттэй гарлаа. Өнгөрсөн оны мөн үед Голомт банкнаас бусад СНББ-ууд дор хаяж 10.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байсан бол энэ онд 3 банкны ашиг л 10.0 тэрбумын босгыг давсан байдалтай байна.



Өнгөрсөн оны мөн үед зөвхөн ҮХОБ алдагдалтай ажиллаж байсан бол энэ онд алдагдалтай ажиллаж буй банкны тоо 3-р нэмэгджээ. Капитрон банкны хувьд ашгийн өсөлтөөрөө Голомт банкны дараа орохоор үзүүлэлтийг үзүүлсэн бол ТХБ болон Богд банкууд тайлант хугацаанд ашигтай ажилласан байна.




Ашигт ажиллагаа буурсан гол шалтгаан нь зээлийн чанар муудсантай холбоотой зээлийн эрсдэлийн сангийн зардал өсч, хүүгийн орлого буурснаар тайлбарлагдахаар байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ. Банкуудын ашигт ажиллагаа буурсан нь зарим банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт буурах шалтгаан боллоо. 2018 оны 3 дугаар улирлын байдлаар өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг 2-с дээш нэгж хувиар биелүүлж байгаа системийн нөлөө бүхий 2 банк байгаа нь Хаан болон Хас банкууд байна.



Бусад банкуудын хувьд нэг банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт зөрчигдсөн байдалтай байгаа бөгөөд 200 тэрбум төгрөгөөс дээш активтай 4 банк (СНББ-уудаас бусад банкуудын хувьд)-ны нэг буюу ТХБ-ны хувьд л зээлийн багцаа 50-с дээш хувиар өсгөх боломжтой байна.



Үүнээс үзэхэд СНББ-ууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээс бусад тохиолдолд зээлийн зах зээлд өрсөлдөхөд хязгаарлагдмал байдал үүсэхээр байна.

Эх сурвалж:

- МонголБанк, Арилжааны банкуудын нэгдсэн тайлан тэнцэл
- Арилжааны банкуудын вебсайт болон хэвлэлд нийтэлсэн санхүүгийн тайлангууд

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар. СНББ-уудын төлбөрийн чадвар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээс дор хаяж 5 нэгж хувиар өндөр байгаа ба Хаан банкны хувьд уг үзүүлэлт 50-с дээш хувьтай байна. Төрийн банкны зээл нэг улирлын дотор 200 орчим тэрбум төгрөгөөр өссөнөөр хөрвөх чадварын харьцаа 10 нэгж хувиар бүүрч 30.6 хувьд хүрснийг эс тооцвол бусад СНББ-ын хувьд огцом өөрчлөлт ороогүй болно.



Чингис хаан банкнаас бусад банкуудын хувьд хөрвөх чадвартай хөрөнгийн нөөц хангалттай өндөр түвшинд байгаа нь өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж чадвал зээлийн багцад хөрөнгө оруулалт хийх боломж байгааг илтгэж байна.



Товчилсон нэрс:

- СНББ-Системийн нөлөө бүхий банк
- ХХБ-Худалдаа Хөгжлийн Банк
- УБХБ-Улаанбаатар Хотын Банк
- ТХБ-Тээвэр хөгжлийн банк
- ҮХОБ-Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк